



“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

# АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Аутизмын хүрээний эмгэг / Аутизмын хүрээний бэрхшээл





## АГУУЛГА

Өмнөх үг.....ii

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

#### Аутизмын хүрээний талаар ойлголттой болохын тулд

1 Аутизмын оношлогооны стандарт .....	1
2 Аутизмын шинж тэмдэг ба хүүхдийн төлөв байдал.....	2
3 Аутизмын шинж тэмдгийн хүнд хөнгөний ангилал.....	3
4 Аутизмтай хавсран илрэх шинж тэмдэг ба хоёрдогч бэрхшээлүүд .....	4
5 Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сайн тал ба хүүхдийн шинж байдал.....	5
6 Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын жагсаалт .....	6

### ХОЁРДУГААР БҮЛЭГ.

#### Монголын Аутизмын холбооны гишүүдээс ирүүлсэн асуултын хариулт

1. Сургуулийн өмнөх насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын асуулт .....	7
2. Сургуулийн насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын асуулт .....	22

## ӨМНӨХ ҮГ

Энэхүү товхимлыг Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид, дэмжлэг үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтнүүдийн аутизмын тухай мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор боловсрууллаа.

Аутизмын хүрээний эмгэг<sup>1</sup> гэдэг нь Аутизм ба Аспергерийн хам шинжийг хамтатган авч үзсэн онош юм. Ерөнхийдөө харилцааны хүндрэлийг үүсгэх бөгөөд туйлширмал зан үйл, явцуу хүсэл сонирхол, давтагдмал үйлдлүүдээр илэрдэг.

“Autism Spectrum Disorder” гэсэн Англи нэршлийг “ASD” товчлон хэрэглэх нь ч бий.

Аутизмын хүрээний эмгэгийн шалтгаан одоо ч тайлагдаагүй. Гэвч тархины үйл ажиллагааны ямар нэг төрөлхийн эмгэг гэж үздэг бөгөөд эцэг эхийн хүмүүжил, хайр халамж дутсан гэх зэрэг эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барилыг шууд шалтгаан нь гэж үзэж болохгүй.

Аутизмын хүрээний эмгэг нь оюуны бэрхшээл хавсарсан, эсхүл хавсраагүй байж болно. Шинж тэмдэг нь хөгжлийн үе шат, нас, хүрээлэн буй орчин нөхцөл зэргээс хамааран харилцан адилгүй байна.

Мөн амьдралд нь саад бэрхшээл учруулах хэмжээнд шинж тэмдэг хүчтэй илэрдэг, эсвэл шинж тэмдэг, зовиур нь хөнгөн, өдөр тутмын амьдралд бараг саадгүй оролцдог гэх зэргээр олон янз байдаг.

Сүүлийн үед ихэр хүүхдийн судалгаа, гэр бүлийн гишүүд хоорондын таарамжийн судалгааг идэвхтэй зохион байгуулдаг болжээ. Гэсэн хэдий ч анагаах ухаан одоогоор тодорхой дүгнэлтэд хүрч чадаагүй байгаа бөгөөд аутизм үүсэхэд ямар нэг удамшлын хүчин зүйл нөлөөлөх магадлал өндөр гэж үздэг байна.

Гэвч удамших магадлал өнөөдөр ч батлагдаагүй хэвээр байна. Эцэг эх нь аутизмтай тохиолдолд хүүхэд нь ч аутизмтай төрөх магадлалтай холбоотой статистик үзүүлэлтүүд харилцан адилгүй байгаа ба баттай үр дүн гараагүй байгаа юм.

Энэхүү товхимолын “Нэгдүгээр бүлэг. Аутизмын хүрээний талаар ойлголттой болохын тулд” бүлэгт Аутизмын оношлогооны стандарт, шинж тэмдэг, сайн тал, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлдэг байгууллагын жагсаалтыг танилцуулсан. “Хоёрдугаар бүлэг. Монголын Аутизмын холбооны гишүүдээс ирүүлсэн асуултын хариулт”-д, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын 29 асуултын хариулт, сургуульд явдаг хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын 30 асуултын хариултыг танилцуулж байна.

<sup>1</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (WHO) баталсан “Өвчний олон улсын ангилал (ICD-10)”-ын “Өргөн хүрээний хөгжлийн бэрхшээл” гэсэн ангилалд Аутизм хэмээх нэр томъёог ашигладаг. АНУ-ийн сэтгэцийн эмч нарын холбооноос 2013 онд хэвлэн гаргасан “Сэтгэцийн эмгэгийн ангилал, оношлогооны гарын авлага (DSM-5)”-д Аутизм хэмээх нэр томъёог хассан ба Аутизмын хүрээний эмгэг гэж нэрлэхээр тогтжээ. Тиймээс энэхүү товхимолд Аутизмын хүрээний эмгэг гэсэн нэр томъёог ашиглав.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

**Аутизмын хүрээний бэрхшээлийн талаар ойлголттой болохын тулд**



## 1. Аутизмын оношлогооны стандарт (DSM)

“Сэтгэцийн эмгэгийн ангилал, оношлогооны гарын авлага (Diagnostic and Statistical Manual of Mental Disorders: DSM)” гэдэг нь АНУ-ийн сэтгэцийн эмч нарын холбооны (American Psychiatric Association) боловсруулсан сэтгэцийн эмгэгийг оношлодог стандарт юм. DSM-V хэмээн товчлон нэрлэсэн 2013 оны уг стандартад “Аутизмын хүрээний эмгэгийн оношлогооны стандарт”-ыг дараах байдлаар тодорхойлжээ.

### DSM-V дахь Аутизмын оношлогооны стандарт 299.00 (F84.0)

А. Нийгмийн харилцаанд орох, бусадтай харилцах байнгын шинжтэй бэрхшээл

1. Нийгэм, сэтгэл зүйн харилцааны бэрхшээл
2. Бусадтай харилцах үгэн бус харилцааны бэрхшээл
3. Насандаа тохирсон харилцааны чадварын бэрхшээл

Б. Хязгаарлагдмал, давтагдмал шинжтэй үйлдэл, сонирхол, хөдөлгөөн

1. Хэвшмэл, давтагдмал хөдөлгөөн, хэл яриа, эсвэл үйлийн хязгаарлагдмал чадвар
2. Явцуу сонирхол, нэг л зүйлд хэт дурласан сонирхол, анхаарал төвлөрөлт болон нэг юманд хэт анхаардаг, зан үйлийн шинжтэй үйлдэл хөдөлгөөн
3. Хязгаарлагдмал, туйлширмал сонирхол, хүчтэй анхаарал төвлөрөлт
4. Мэдрэхүйн үйлийн эмзэг, мэдрэмжгүй байдал, мэдрэхүйтэй холбоотой орчин тойрны ер бусын сонирхол

В. Шинж тэмдэг нь ихэвчлэн хөгжлийн эрт үед илрэх боловч, зарим тохиолдолд хожуу илэрнэ.

Г. Нийгэм олон нийт, ажлын байр болон бусад чухал үйл ажиллагаанд ноцтой саад бэрхшээл үүсэх магадлалтай

## 2. Аутизмтай хүүхдийн төлөв байдал

Аутизм нь бусадтай харилцахдаа тааруу, хэт туйлширмал гэдгээрээ онцлог бөгөөд аутизмтай хүүхдэд дараах онцлог шинжүүд илэрдэг.

1) Хэл ярианы хөгжил нь хоцордог

Хэл ярианы хөгжил хоцромтгой. Үг бараг хэлэхгүй, этгээд хачин дуу авиа, дохио зангаагаар харилцдаг.

2) Echolalia

Бусад хүний яриа болон асуултыг тоть шиг давтана.

3) Этгээд хачин аялга, дуудлагатай

Хэвийн бус, этгээд хачин аялгаар ярина.

4) Асуултад бараг хариулахгүй

Харилцан ярианд хариу үйлдэл үзүүлэхгүй. Яриа өдөх, асуулт асуухад огт сонсоогүй мэт дүр эсгэх ба ганцаараа ярих, эсвэл шал өөр үйлдэл хийнэ.

5) Хүн рүү эгцэлж харахгүй

Хүний нүд рүү бараг харахгүй, өөдөөс нь харж ярьсан ч эгцэлж харахгүй.

6) Харилцан ярихад төвөгтэй

Харилцан ярихад маш төвөгтэй. Асуултад огт хариулахгүй, зөвхөн өөрөө юу ч хамаагүй ярина.

7) Туйлширмал сонирхолтой

Хэт явцуу, туйлширмал сонирхолтой. Зөвхөн дуртай тоглоомоороо тоглож, байнга түүнийгээ авч явна.

8) Давтагдмал зан үйл (Үргэлж нэг үйлдлээ давтдаг)

Үргэлж нэг үйлдлээ давтана. Жишээ нь, хаалгыг зогсоо зайгүй хааж нээх, адилхан зүйлүүдийг нэг газарт яг ижил байдлаар эгнүүлж өрөх гэх мэт.

9) Хэт эмзэг мэдрэхүйтэй

Харах, сонсох, хүрэх, үнэрлэх, амтлах зэрэг янз бүрийн мэдрэхүйн тал дээр хэт эмзэг. Ялангуяа хүн олонтой (Чимээ шуугиантай) газар байх дургүй, зарим нэг дуу хөгжим, чимээнд маш их дургүйцдэг.

10) Зөрүүд, тодорхой нэг зүйлд хэт дуртай

Тодорхой нэг зүйлд хэт дурлах ба дуртай зүйлээ гараасаа огт салгахгүй. Хийж байгааг нь болиулбал уйлж орилж хашгична, эсвэл маш ихээр уурлаж бухимдана.

Өмнө дурьдсан оношлогооны стандарт болон хүүхдийн төлөв байдалд хамаарах шинж тэмдгүүд анзаарагдвал юуны өмнө мэргэжлийн эмнэлэгт хандах нь зүйтэй юм. Мэргэжлийн эмнэлэгт хүүхдийн гаргаж буй үйлдлүүдийг ажиглах, ярилцаж үзэх, мөн сэтгэл зүйн сорил авдаг. Энэ мэтээр хүүхдийн байдлыг цогцоор нь үнэлж оношлодог.



### 3. Аутизмын шинж тэмдгийн хүнд хөнгөний ангилал

DSM-V-д Аутизмын хүрээний шинж тэмдгийн хүнд хөнгөний ангиллыг А. Нийгмийн харилцаа, Б. Хязгаарлагдмал, давтагдмал үйлдлээр нь дараах 3 түвшинд хуваан авч үздэг.

Түвшин	А. Нийгмийн харилцаа	Б. Хязгаарлагдмал, давтагдмал үйлдэл
<p><b>Түвшин 3</b></p> <p><b>Дэмжлэг зайлшгүй шаардлагатай</b></p>	<p>Үгэн болон үгэн бус харилцааны чадваргүй тул сэтгэл санаа, бие махбодын үйл ажиллагаа маш их доголдох ба нийгмийн харилцаанд орж чадахгүй, бусад хүн өөртэй нь харьцахад огт хариу үйлдэл үзүүлэхгүй.</p>	<p>Үйлдэл нь уян хатан биш, гэнэтийн өөрчлөлтийг хүлээн авахдаа маш муу. Үйлдэл нь хязгаарлагдмал, давтагдмал шинжтэй тул хөгжлийн бүх айд мэдэгдэм бэрхшээлийг үүсгэдэг. Анхаарлын болон үйлдлийн өөрчлөлт ноцтой хүндрэл дагуулна.</p>
<p><b>Түвшин 2</b></p> <p><b>Тал бүрийн дэмжлэг шаардлагатай</b></p>	<p>Үгэн болон үгэн бус харилцааны чадвар сул учир тохирох дэмжлэг үзүүлсэн ч нийгэмшихүйд болон нийгмийн харилцаанд ороход нь хүндрэл үүсэх ба бусад хүн өөртэй нь харьцахад бараг хариу үйлдэл үзүүлэхгүй, эсвэл этгээд хариу үйлдэл үзүүлнэ.</p>	<p>Үйлдэл нь уян хатан биш, гэнэтийн өөрчлөлтөд дасан зохицохдоо муу. Үйлдлийн хязгаарлагдмал, давтагдмал шинж нь энгийн хүний нүдэнд ч илт анзаарагдана. Анхаарлын болон үйлдлийн өөрчлөлт нь хүндрэлийг дагуулна.</p>
<p><b>Түвшин 1</b></p> <p><b>Дэмжлэг шаардлагатай</b></p>	<p>Дэмжлэг үзүүлэхгүй бол харилцааны чадвар дутагдана. Нийгмийн харилцаанд орохдоо муу, бусад хүн өөртэй нь харьцахад нэгэн хэвийн бус, өөр хоорондоо холбоогүй хариу үйлдэл үзүүлдэг. Нийгмийн харилцаанд орох сонирхолгүй байх магадлалтай.</p>	<p>Уян хатан бус үйлдэл нь нэгээс дээш тохиолдолд мэдэгдэхүйц хүндрэл тулгардаг. Үйлдлээ зогсоож, дараагийн үйлдэлд шилжих зэрэг гэнэтийн өөрчлөлтөд тааруу. Эмх цэгцтэй, дэс дараалалтай үйлдэл болон бие дааж хийх үйлдэл дээр асуудалтай.</p>

#### 4. Аутизмтай хавсран илрэх шинж тэмдгүүд ба хоёрдогч бэрхшээл

##### ■ Оюуны бэрхшээл

Оюуны үйл ажиллагаа нь ерөнхийдөө хоцрогддог. Ялангуяа хэл ярианы хөгжлийн хоцрогдол давамгайлна. Жишээлбэл, хүний хэлснийг ойлгохгүй, зөвхөн өөрийнхөө дураар тоглож буй мэт харагдаж андуурагддаг.

##### ■ Хэт хөдөлгөөнтэй, түргэн цочмог

Өрөөн дотуур тойрч гүйнэ, үсэрч харайна, эсвэл зогсолтгүй эргэлдэж хөдөлнө.

##### ■ Сэтгэл зүйн хувьд тогтворгүй (Чанга, хачин дуу авиа гаргах, хэт уурлах, цохиж нүдэх гэх мэт)

Уйлж хашгична, юм цохиж нүднэ, утга учиргүй инээнэ, уурлана, хөөрнө гэх мэтчилэн сэтгэл санаагаа илэрхийлэхдээ тааруу.

##### ■ Өөрийгөө гэмтээх үйлдэл

Санаснаар нь болохгүй бол уурлаж уйлагнана, өөрийнхөө толгой, нүүрийг балбана, эргэн тойрны хүмүүст уураа гарган цохиж нүднэ, эсвэл гараа хазна.

##### ■ Эв дүй муутай, болхидуу

Нарийн чимхлүүр хөдөлгөөн хийх болон хөдөлгөөнөө зохицуулахдаа тааруу байх зэрэг байдал ажиглагдана.

##### ■ Уналт таталт

Уналт таталт өгөх тохиолдол бий. Гэхдээ эмийн эмчилгээ сайн хийж хяналт тавьбал биеийн байдал нь сайжирч эдгэх боломжтой.

##### ■ Нойрны асуудал

Нойрны асуудал үүсдэг. Зөв дэглэм, цагийн хуваарийн дагуу унтаж босч чадахгүй.

\* Хүүхэд бүрт харилцан адилгүй, ялгаатай байх бөгөөд аутизмтай бүх хүүхдэд хоёрдогч бэрхшээл хавсарч илэрдэг гэсэн үг биш.

Дээр дурьдсан зүйлүүд нь зөвхөн нийтлэг жишээ юм.



## **5. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сайн тал ба хүүхдийн төлөв байдал**

1) Харааны ой тогтоолт маш сайн

Янз бүрийн таних тэмдэг, тэмдэглэгээг маш олноор цээжилчихсэн хүүхэд ч байдаг.

2) Өвөрмөц зураг зурдаг

Өвөрмөц содон зураг зурах, нарийн хуулж зурахдаа гарамгай.

3) Тодорхой нэг зүйлд ажиглагддаг авъяас чадвар

Туйлширмал сонирхолтой хүүхэд олон тохиолдох ба тодорхой нэг зүйлийг маш хурдан сурч эзэмшдэг. Эсвэл аливаа зүйлийг ангилж цэгцлэхдээ сайн байх нь элбэг. Тэдний зарим нь дуртай зүйлээ туйлын нарийн нямбай хийдэг, мөн эд зүйлүүдийг өнгө, хэлбэрээр нь ялгаж төрөлжүүлэхдээ онцгой сайн байдаг.

4) Дуу хөгжмийн мэдрэмж маш сайн

Нэг сонссон дуугаа тэр дор нь цээжилнэ. Дууны хэмжээг сайн ялгаж чаддаг. Төгөлдөр хуур тоглож сурах чадвар маш сайтай.

## 6. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд ба асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлж буй байгууллагуудын жагсаалт

Танд хүүхэд өсгөхтэй холбоотой ямар нэг хүндрэл учирвал, зөвхөн ганцаараа шаналах бус дараах байгууллагуудад хандан туслалцаа хүсч, зөвлөгөө авч болно.

Байгууллагын нэр	Хаяг	Утас
<b>Эцэг эхийн холбоо</b>		
Монголын Аутизмын холбоо ТББ	Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж	9913-8914 8618-1800
Аутизм Монгол анд ТББ	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Туул гол гудамж, 69А байр	7013-4053 8846-4343
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо ТББ (ХБХЭЭХ)	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Шинэ мөрөөдөл хотхон, 24/3 байр, 1 тоот *Улаанбаатар хотоос гадна 13 аймагт салбартай.	7012-3336 9445-9999
<b>Эмнэлэг</b>		
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ)	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 9-р хороо, 50-р гудамж	11-458298
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)	Баянгол дүүрэг, Хувьсгалчдын гудамж	11-362205 11-27011
* Бүх аймаг, бүх дүүрэг Эрүүл мэндийн төвтэй (2 дахь шатлалын эмнэлэг).		
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс		
* Бүх аймаг, бүх дүүрэгт салбар комисс ажилладаг. Салбар комиссын даргын үүргийг тухайн аймаг, дүүргийн Нийгмийн бодлого/хөгжлийн хэлтсийн дарга гүйцэтгэж байна.		
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, сэргээн засалтын байгууллага		
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж	7777-2001
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах төв	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж	7777-2002
<b>Цэцэрлэг, сургууль</b>		
Бүх аймагт Боловсрол, соёл, урлагийн газар, Нийслэлийн бүх дүүрэгт Боловсролын хэлтэс ажилладаг. Эдгээр байгууллагад хандан цэцэрлэг болон бага, дунд сургуульд хүүхдээ хамруулах талаар ярилцаж зөвлөх боломжтой.		
Улаанбаатар хотод оюуны болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэд хүлээн авдаг 4 тусгай сургууль бий. Эдгээр тусгай сургуулиудад “Эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн зөвлөл” ажиллаж байна.		
25-р тусгай сургууль	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо	11-326354 11-320868
55-р тусгай сургууль	Баянзүрх дүүрэг, 13-р хороо	11-455447 11-451594
63-р тусгай сургууль	Хан-Уул дүүрэг, 4-р хороо	11-379474
70-р тусгай сургууль	Баянгол дүүрэг, 18-р хороо, 4-р хороолол	7014-4106
Монголын тусгай цэцэрлэгүүдийн холбоо ТББ	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Нисора цамхаг, 5 давхар	9511-9580
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг, яслийн 10-р цогцолбор	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Өнөр бүл төвийн цэцэрлэг, ц58-р байр	11-451655 7000-1655
186-р тусгай цэцэрлэг	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо	5316-0171 9324-0001
МУБИС-ын харьяа 249-р цэцэрлэг	Баянгол дүүрэг, 17-р хороо	7011-2328



“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.



Autism Association  
of Mongolia

“Монголын Аутизмын Холбоо” ТББ-ын  
Эцэг эхчүүдийн асуултад өгсөн хариулт



## 1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АСРАН ХАМГААЛАГЧДЫН АСУУЛТ



## **Асуулт 1: Яагаад миний хүүхэд аутизмтай болсон юм бол? Аутизм нь зүгээр болох уу?**

**Хариулт 1:** Аутизмын шалтгааныг одоо ч тайлж чадаагүй байна. Гэхдээ аутизмыг тархины үйл ажиллагааны төрөлхийн эмгэг гэж үздэг бөгөөд эцэг эхийн хүмүүжил, хайр энэрэл дутсанаас аутизм үүсдэггүй гэдэг нь тодорхой.

Тархины үйл ажиллагааны эмгэг үүсэх механизмыг удамшлын шинжтэй байх магадлалтай гэж таамагладаг. Энд дурдсан удамшлын шинжтэй гэдэг нь заавал эцэг эхээс удамшсан байх албагүй, төрөлхийн гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл эхийн хэвлийд ураг бүрэлдэх явцад ургийн тархины хөгжилд ямар нэгэн зүйл нөлөөлсний улмаас гэнэт өөрчлөлт орсон гэж үздэг.

Өнөөгийн анагаах ухаанд аутизмыг үндсээр нь эмчлэх арга технологи хараахан байхгүй. Гэхдээ чанартай сэргээн засалт болон сургалт, тохирох эмчилгээ, дэмжлэгийг үзүүлснээр илрэх шинж тэмдгийг хөнгөвчлөн байдлыг сайжруулах замаар бэрхшээлийг нь даван туулах боломжтой.

## **Асуулт 2: Манай хүүхэд ярьдаггүй болохоос бүгдийг ойлгодог. Бас хэрэгтэй үедээ хүн рүү хардаг, юу хүсч байгаагаа ойлгуулж чаддаг. Тийм болохоор миний хүүхэд аутизмтай гэдэгт би итгэхгүй байна. Үүнийг юу гэж ойлгох вэ?**

**Хариулт 2:** Аутизмын оношлогоонд “Хэл яриа, харилцааны хөгжлийн хоцрогдол”, “Бусадтай харилцах, нийгэмшихүйн ноцтой бэрхшээл”, “Үйлдэл, сонирхлын хүчтэй туйлшрал, хэт хүчтэй мэдрэмж, эсвэл хэт мэдрэмжгүй байдал” гэсэн 3 суурь хүчин зүйлийг баримталдаг.

Хүний ярьж хэлснийг ойлгодог ч ижил насных нь хүүхдүүдтэй харьцуулахад хэл ярианы илт хоцрогдол (Үг хэлэх, харилцан ярилцах) анзаарагдаж байвал, түүнчлэн шалтгааныг нь мэдэхгүй байгаа тохиолдолд аутизмтай байх магадлалтай гэж үздэг. Илэрхийлэх чадварын хувьд, бусдын анхаарлын төвд байх гэсэн үйлдэл бус, эргэн тойрны хүмүүсийн хэлсэн үг, үйлдэлд тохирох хариу үйлдэл үзүүлэх чадвар байгаа эсэхийг нь оношлогооны гол анхаарах зүйл болгодог. “Над аа”, “Ингэх үү, тэгэх үү” гэх зэрэг асуултад тохирох хариу үйлдэл үзүүлж чадахгүй байдал олон удаа ажиглагдаж байвал, бусадтай харилцах харилцааны асуудал гэж ойлгоно.

### **Асуулт 3: Дахин хүүхэдтэй болбол, тэр хүүхэд маань аутизмтай төрөх магадлал хэр их вэ?**

**Хариулт 3:** Энэ талаар олон судалгаа байдаг бөгөөд үр дүн нь янз бүр байна. Ах дүүсийн аль нэг нь аутизмтай оношлогдсон тохиолдолд, ах дүү нь аутизмтай байх магадлал нь 5-10% гэж үздэг. Ихрүүдийн хувьд нэг өндгөн эсийн ихрийн тухайд 91-96%, хоёр өндгөн эсийн тухайд 0-24% гэсэн судалгааны тайлан ч байдаг. Ах дүүс дотор хэн нэг нь аутизмтай бол дахин аутизмтай хүүхэд төрөх магадлал өндөр гэж үзэх хандлага байдаг хэдий ч удамшлын хүчин зүйл хүчтэй нөлөөлсөн гэж үзсэн нөхцөлд ч заавал аутизмтай төрнө гэсэн үг биш юм.

### **Асуулт 4: Манай хүүхдэд чадахгүй зүйл олон байдаг. Хүүхэдтэйгээ ажиллаж, хүүхдээ хөгжүүлмээр байна. Гэхдээ хаанаас эхлэж, юу хийвэл дээр вэ гэдгээ мэдэхгүй байна.**

**Хариулт 4:** Нэн тэргүүнд өөрөө хооллох, бие засах, хувцсаа солих, унтах зэрэг өдөр тутмын амьдралын дадал чадвар, хэмнэлд сургах нь чухал. Түүнчлэн эцэг эх, бусад хүүхэд, гэр бүл, ойр төрлийн хүнтэйгээ харилцах чадварт тоглоомоор дамжуулан сургаж, зориуд эзэмшүүлэх ёстой.

Гэвч хүүхэд бүрийн хөгжил харилцан адилгүй юм. “Хөдөлгөөн”, “Амьдралын дадал хэвшил”, “Хэл яриа”, “Танин мэдэхүй”, “Нийгэмшихүй” зэрэг хөгжлийн айд аутизмтай хүүхдийн хөгжил жигд бус байдаг. Аутизмтай хүүхдэд үйлдэл, туйлширмал сонирхлоос үүдэлтэй хэт хөдөлгөөнтэй, цочмог байдал хүчтэй илрэх ба сэтгэл санааны тайван бус байдлын улмаас чанга дуугаар орилж хашгирах, эсвэл янз бүрийн асуудалтай үйлдэл гаргах нь бий. Эцэг эхчүүд нь эмч, сэргээн засалч болон хүүхдийн хөгжлийн талаар мэдлэг туршлагатай мэргэжилтнүүдээс хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдол болон хэлбийлт (Жигд бус хөгжил), асуудалтай зан үйлийн талаар хамгийн түрүүнд юун дээр илүү анхаарч ажиллах талаар зөвлөгөө авч болно.



## **Асуулт 5: Ганцаараа инээдэг, заримдаа гэнэт уйлдаг нь ямар учиртай юм бол?**

**Хариулт 5:** Аутизмын эмгэгийн нэг шинж нь өөрийн ертөнцөд, бодит бус хийсвэр зүйлд дурлах хандлага юм. Толгой дотроо тухайн нөхцөл байдалтай үл нийцэх хөгжилтэй зүйлийг өөрийн бие дээр төсөөлж бодох, эсвэл огт байхгүй нөхцөл байдал, зүйлийг хийсвэрлэн төсөөлж баясах явдал байдаг. Тийм үед тухайн орчинтой нийцэхгүйгээр ганцаараа инээж, баярладаг. Мөн хүчтэй санаа зовнил, сэтгэл санааны гэнэтийн өөрчлөлтөд (Гэнэт хямарч, гэнэт тайвшрах зэргээр сэтгэл санааны байдал нь огцом өөрчлөгддөг) ордог аутизмтай хүн ч цөөнгүй. Ийм тохиолдолд, тухайн орчин нөхцөлтэйгээ огт хамааралгүйгээр уйлж, эсвэл уурладаг байна. Энэ үед авах арга хэмжээний хувьд, бодол санааг нь бодит нөхцөл байдалд нь буцаан оруулах зорилгоор дуудаж, анхаарлыг нь бодит зүйлд хандуулж тайвшруулах аргыг хэрэглэдэг байна.

## **Асуулт 6: Хүүхэд маань шөнө унтахгүй маш их уддаг, эсвэл шөнө сэрээд буцаж унтахгүй юм. Яагаад тэгдэг юм бол? Нойрны асуудлыг нь хэрхэх зохицуулах вэ?**

**Хариулт 6:** Нойрны асуудалтай болон нойрны хэмнэл нь тогтворгүй аутизмтай хүмүүс элбэг тохиолддог. Ийм хүмүүсийн хувьд мэдрэхүй хэт эмзэг байдаг тул тархи нь янз бүрийн өдөөгчид хүчтэй хариу үйлдэл үзүүлдгээс шалтгаалдаг. Ялангуяа бага насны хүүхдийн хувьд шөнө сэрэх, орондоо шээх, тавгүй унтах зэрэг байдлаар илэрнэ. Нойрны асуудал нь хэт хүнд байгаа бол эм хэрэглэх талаар бодолцох хэрэгтэй ба нам тайван нойрсуулах үүднээс дэмжлэг шаардлагатай болно. Шөнө сэрэх, босоод инээгээд байх зэрэг шинжүүд нь тархи амарч чадахгүй, маргааш өдрийнх нь үдээс өмнө сэтгэл санаа тайван бус байх, эсвэл анхаарлаа удаан төвлөрүүлж чадахгүй зэргээр зан үйлийн асуудлуудыг үүсгэдэг. Тиймээс өдрийн цагаар биеийг нь аль болох сайн хөдөлгөж, нар салхинд гаргах зэргээр эрүүл, идэвхтэй хөдөлгөөн хийлгэх, харин үдэш шүршүүрт оруулан биеийг нь дулаацуулах, өрөөний гэрлийг нь унтраан чимээгүй орчинд тайван унтах боломж бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай.

## **Асуулт 7: Манай хүүхэд маш цөөн төрлийн хоол идэх юм. Ялангуяа ногоо иддэггүй. Яаж олон төрлийн хоол иддэг болгох вэ?**

**Хариулт 7:** Ихэнхдээ хүүхдийн хэт хүчтэй мэдрэхүйгээс шалтгаалдаг бөгөөд үнэр, амт болон харагдах байдлаас нь болоод хүнсний ногооны өнгө, хэлбэр зэргийг үл таашаан, дургүйцэх тохиолдол цөөнгүй. Хүүхдийн бие махбод, уураг тархины хөгжилд чухал, тэнцвэртэй, шим тэжээл бүхий хоол өгөх шаардлагатай байдаг. Гэтэл хүчээр аманд нь хийх зэргээр шахвал, цөөн төрлийн хоол иддэг байдал нь улам даамжирахад хүрнэ. Идэх дуртай зүйлийг нь харуулаад “Гүрийж байгаад жаахан идчихвэл дуртай юмыг чинь өгнө шүү” гэх зэргээр аргалж тохиролцоо хийж сурах хэрэгтэй. Ногоогоо хэрчиж жижиглэн мэдэгдэхгүй болгоод хоолонд хольсон ч гэсэн хэдийгээр хүүхдийн ходоод гэдэс нь шингээж чадах боловч, өөрийнх нь хэт хүчтэй мэдрэмжийг бууруулах, хүлээн зөвшөөрүүлэх, ойлгуулахад ямар ч нэмэргүй. Хүүхдэдээ сайн тайлбарлаж өгөөд бага багаар идэж сурах дасгал хийлгэж болно.

## **Асуулт 8: Хүүхэд маань гадаа гарвал харсан зүгтээ гүйгээд явчихдаг. Насан туршид нь хөтлөөд яваад байх уу? Хэзээ хүртэл хөтөлж явах ёстой вэ?**

**Хариулт 8:** Аутизмтай хүүхэд нялх байхаасаа балчир нас хүртлээ хэт хөдөлгөөнтэй, маш цочмог байдаг бөгөөд идэвхтэй хөдөлгөөн хийх, гүйж харайх байдлаар өөрийгөө өдөөн (Бие, эрхтнийхээ хөдөлгөөнөөр өөрийгөө өдөөх) сэтгэл ханамж авах хандлага элбэг тохиолдоно. Хөдөлгөөн ихтэй, тайван бус хүүхдийг 6 нас хүртэл байнга гараас нь хөтөлж явах шаардлагатай болно. Гүйж харайхад аюул осол багатай газарт тоглуулах гэж буй бол анхаарал болгоомжтой байхыг сайтар анхааруулан хүүхдээрээ амлуулах зарчмыг баримтлах хэрэгтэй. Зай талбайтай газарт чөлөөтэй гүйх боломжтой болмогц илүү их хөдөлж гүймээр санагдах тул хүүхдийн тань хөдөлгөөн улам идэвхжинэ. Тиймд гараас нь хөтлөөд томоотой алхуулах, чөлөөтэй гүйхийг нь зөвшөөрөх гэсэн хоёр нөхцөл хоёулаа шаардлагатай. Ийм оролдлогоор дамжуулан хүүхдийг өөрийн үйлдэл, хөдөлгөөнөө хянахад сургадаг.

### **Асуулт 9: Манай хүүхэд хэтэрхий хөдөлгөөнтэй. Өдөржин гүйгээд юм руу авираад байдаг. Тархийг нь амраах хэрэгтэй гэж эмч хэлсэн. Хүүхдэдээ тайвшруулах эм өгөх нь зөв үү?**

**Хариулт 9:** Дандаа өндөр юм руу авираад байдаг, эсвэл хэтэрхий удаан гүйж харайгаад байдаг бол биеийн хөдөлгөөнөөрөө дамжуулан санамсаргүй байдлаар тархиа өдөөж, түүнээсээ сэтгэл ханамж авдаг аутизмтай хүүхэд ч цөөнгүй тохиолдоно. Эрчимтэй хөдөлгөөнийг хэт удаан давтаж үргэлжлүүлдэг, улмаар эргэн тойрных нь хүмүүс болиулж чадахгүй байгаа үед эмчийн заавраар тайвшруулах эм уулгадаг. Гэхдээ тайвшруулах эм хэрэглэхэд хүүхдийн сэргэг байдал буурч, биед нь ямар нэг зовиур илрэх тохиолдол ч гардаг. Тиймээс гэр бүлийнхэн нь хүүхдээ асрахад гардаг ачаалал хүндрэлийг ч анхааран тооцож үзэх шаардлагатай. Хүүхэд бүрт харилцан адилгүй байдаг боловч 6 орчим наснаас хойш томрох тусмаа харьцангуй тайван болдог хүүхэд олон байх тул сургуулийн өмнөх насанд нь тодорхой хэмжээнд ойлгож тэвчих нь зүйтэй.

### **Асуулт 10: Манай хүүхэд зарим дуу чимээнээс айгаад чихээ таглаад хашгирч уйлдаг. Бас зарим нэг юмыг барьж чаддаггүй, эсвэл харж чаддаггүй. Бүх зүйлийг үнэрлэж үздэг. Энэ хэт их мэдрэмжийг нь бууруулах боломжтой юу?**

**Хариулт 10:** Хэт хүчтэй мэдрэхүйтэй нь холбоотой. Энэ нь аутизмтай хүмүүсийн хувьд нэлээд ноцтой асуудал бөгөөд хүндрэл бэрхшээлийг дагуулна. Мэдрэхүйн хувьд зарим зүйлд (Дуу чимээ, үнэр амт, хүрэлцэх мэдрэхүй зэрэг) хэтэрхий дургүйцэж зайлсхийхийн нөгөөтэйгүүр зарим зүйлийг илүү хүчтэй мэдэрч, хэт дурлах тохиолдол ч гарна. Их дургүйцдэг бол хэт хүчлэхгүйгээр, бага байхаас нь аажмаар дасгаж (Туршуулах) болно. Ингэхдээ аль болох тайван байлгаж, бага багаар туршуулж үзэх шаардлагатай. Яаж ч хичээсэн айгаад байдал сайжрахгүй байвал, жишээ нь чанга дуу чимээнээс дургүйцээд байгаа бол дуу чимээний хязгаарлагчтай чихэвч зүүлгэх арга хэрэглэж болох юм. Харин зарим зүйлд хэт дурлаж туйлшран, салахгүй зуураад байвал тухайн байгаа газар, нөхцөл байдалдаа тохируулан хэрхвэл зохихыг нь заангаа болохгүй байгаа зүйлд нь тааруулж болиулах талын арга хэмжээ авахыг зөвлөө. Гэхдээ их албадаж хүчлэвэл эсрэг үр дагаварт хүргэж болзошгүй тул анхаарах хэрэгтэй.

### **Асуулт 11: Манай хүүхэд зурагтаар сонссон үг өгүүлбэр, эсвэл хэн нэгний хэлснийг давтаж хэлээд байх юм. Ингэж ямар ч холбогдолгүй, утгагүй юм яриад байвал яах ёстой вэ?**

**Хариулт 11:** Аутизмтай хүүхэд хэт туйлширсан сонирхолтой байх, эсвэл тодорхой нэг зүйлд хүчтэй татагдан давтагдсан үг хэллэг, үйлдэл үзүүлэх байдал элбэг тохиолдоно. Энэ нь ихэнхдээ телевизийн реклам, дуртай хүүхэлдэйн кино, уран сайхны киноны үг хэллэг байдаг. Хүүхдийн тань өөрийнх нь хүсэл сонирхол гэдэг утгаараа чөлөөтэй байлгаж болно. Өөрт нь зугаатай байгаа бол тодорхой хугацаанд тоть шиг дуурайх, давтаж хэлэх зэргийг тэвчин хүлээн авч сурах нь зүйтэй. Гэхдээ хаана байгаа, ямар нөхцөл байдалд байгаагаа огт бодохгүй, бусдад тааламжгүй сэтгэгдэл төрүүлэхүйц хэмжээнд давтаж дууриаж хэлээд байвал, бусдад төвөг учруулаад байгааг нь хэлж өгөөд болиулах арга хэмжээ авах хэрэгтэй.

### **Асуулт 12: Хүүхдэдээ ямар нэг юм хэлэх гэхээр наашаа огт харахгүй, өөр тийшээ харах, эсвэл бүр харц буруулаад байдаг. Анхаарлыг нь өөртөө хандуулахын тулд яах ёстой вэ?**

**Хариулт 12:** Ихэнх аутизмтай хүмүүс бусад руу эгцэлж харах дургүй байдаг бөгөөд хүний нүд рүү харахаараа тавгуйцдэг. Тиймд хэт хүчлэхгүйгээр “Хүнтэй ярихдаа нүүр өөд нь харж бай, өөдөөс нь эгц харж зогсоорой” гэх зэргээр хэлж өгч болно. Ялангуяа 3 орчим нас хүрэхээрээ хөдөлгөөн, сонирхол нь улам тэлж, энэ үедээ анхаарлаа төвлөрүүлэх чадвар нь сулардаг. Түр боловч анхаарал хандуулан хүн рүү харвал хангалтгайд тооцож болох бөгөөд хүн рүү харах хугацааг нь бага багаар уртасгахын тулд тэвчээртэй хандаарай.

**Асуулт 13: Манай хүүхэд ямар нэг зүйл авахыг хүсэхээрээ уйлах, газар унах, орилж хашгирах зэрэг байдал гаргадаг. Үүнийг яаж болиулах вэ?**

**Хариулт 13:** Бага байхдаа бусдын анхаарлын төвд байхыг эрмэлзсэн үйлдэл гаргаж, янз бүрийн зүйл нэхдэг. Санаснаар нь болохгүй бол уурлаж бухимдах, уйлагнах гэдэг мэдээж зөвхөн аутизмтай хүүхдээр хязгаарлагдахгүй. Гэхдээ аутизмтай хүүхдийн хувьд энэ хугацаа арай урт байх, эсвэл татгалзах болон хүсэмжлэх байдал нь хэрээс хэтрэх хандлагатай байдаг. Сэтгэл санаа нь тайван бус болж, асуудалтай үйлдэл гаргаад байгаа бол, юуны өмнө тухайн байгаа газраас нь холдуулж тайвшруулах арга хэмжээг авах хэрэгтэй. Нөхцөл байдлаа ойлгодог болж, болох гэж буй зүйлийг таамаглаж сураад ирэхрээ асуудалтай үйлдэл нь аяндаа багасна. Гадагш дагуулж явахад гэрийнхнээ нэлээд сандаргах боловч энэ нь бага насны хүүхдээс гардаг энгийн зүйл бөгөөд өсч томрох тусам байдал сайжирч, хэлснийг ойлгож дагадаг болж ирэх тул цөхрөлгүй, хүлээцтэй хандах нь чухал юм.

**Асуулт 14: Чаддаг байсан зүйлээ гэнэт чадахаа больчихдог нь ямар учиртай юм бэ? Өөрөө зүв зүгээр алхаад явдаг байснаа заавал тэврүүлнэ гээд байх боллоо. Зурагт үзэж байснаа гэнэт үзэхгүй, унтраа гээд байдаг болчихсон.**

**Хариулт 14:** Ихэнхдээ чадвар буурсан юм уу, ямар нэг өвчин туссан гэсэн үг биш. Сонирхол нь өөр болсон, эсвэл зөвхөн өөрийн хүссэнээрээ л байх хүсэл нь давамгайлсан байж магадгүй. Хэт их санаа зовж, эсвэл хэт үглэхгүйгээр хэсэгтээ харзнах нь зүйтэй.

### **Асуулт 15: Өөрийгөө гэмтээх үйлдлийг нь (Гараа хазах, толгойгоороо мөргөх зэрэг) яаж болиулах вэ?**

**Хариулт 15:** Бухимдаж тавгүйцэх, эсвэл санаснаар нь болоогүй үед өөрт нь таагүй санагдвал өөрийгөө гэмтээх үйлдэл хийдэг хүүхэд цөөнгүй. Юуны өмнө тийм нөхцөл байдлыг үүсгээд байгаа асуудлыг нь алга болгож, хүүхдэдээ тааламжтай орчин бүрдүүлж өгөх нь зүйтэй. Мөн шууд “Болохгүй”, “Боль” гэж хэлэх бус, цохиж мөргөөд байгаа хүүхдийн гар болон толгойг нь гараараа хамгаалж болиулна. Тэгээд ямар нэг өөр зүйл болон үйлдэлд анхаарлыг нь хандуулах, тайтгаруулах арга хэмжээ авна.

### **Асуулт 16: Өөрийгөө гэмтээх үйлдэл биш ч бусдад төвөгтэй, этгээд үйлдлүүдийг нь (Гараа сэгсчих, дороо эргэлдэх, нүднийхээ өмнө хуруугаа сарвалзуулах, янз бүрийн хачин дуу авиа гаргах зэрэг) болиулах ёстой юу?**

**Хариулт 16:** Бага насны хүүхэд нь бусдад төвөгтэй санагдах, эсвэл хачин жигтэй харагдах гэдгийг бараг ойлгохгүй байх нь их. Ялангуяа, аутизмтай хүүхдүүд иймэрхүү зүйлийг ойлгож ухамсарлах чадвараар сул байдаг. Тиймээс нөхцөл байдал болон бусдын сэтгэл санаа, сэтгэл хөдлөлийг өдөр тутамд тодорхой үг хэллэгээр (“Тэр дургүй байна”, “Надад уйтгартай санагдаад байгаа болохоор ...-сний хэрэггүй, харин ...-ээрэй”, “Онцгүй харагдаж байна, болиорой” зэрэг) хэлж ойлгуулна. Цөхрөлтгүй, олон дахин хэлж өгөхөд хүүхэд ойлгож ухамсарладаг болно.



## **Асуулт 17: Манай хүүхэд хэзээ ярьж сурах бол?**

**Хариулт 17:** Ярьж сурах тал дээр хүүхэд бүр харилцан адилгүй. Тухайн хүүхдийн хөгжлөөс нь хамааран өөр өөр байна. Хэл яриа нь бусадтай харилцах харилцааны явцад хөгжиж байдаг. Яриулах гэж шууд шавдуулах бус, янз бүрийн хүнтэй харилцан ярих боломж олгон, бусадтай харилцах хүсэлтэй болгох шаардлагатай. Оюуны хөгжлийн бэрхшээл нь хүнд байгаа тохиолдолд утгатай үг хэлж чаддаггүй хүүхдүүд ч байдаг.

## **Асуулт 18: Манай хүүхэд хэлд орж эхэлж байснаа гэнэт ярихаа больчихсон. Эргээд ярьж болох уу?**



**Хариулт 18:** 1-3 настайдаа сурсан үгээрээ ярихаа болих (Чадвар алдах) явдал зарим аутизмтай хүүхдэд гардаг. Үүнийг ухрах аутизм гэнэ. Чадвар алдсаныхаа дараа нэг хэсэгтээ огт ярихаа больчихдог. Харин зарим хүүхэд дахиад ойр зуурын үгээр ярьж эхэлдэг. Гэвч иймэрхүү ухрах аутизмтай хүүхдийн хөгжил нь их удаан байдаг гэсэн судалгаа ч байдаг.

## Асуулт 19: Харилцан ярих чадварыг нь хөгжүүлэхийн тулд гэртээ юу хийх ёстой вэ?

**Хариулт 19:** Өдөр тутмын амьдрал, тоглоомын явцад ойр орчмынхоо хүмүүсээс ямар нэг зүйл хүсэх болон хэлэх гэсэн санааг нь дэмжин хөгжүүлэх хэрэгтэй. Үүний тулд, тохиолдсон болон үзэж харсан зүйлээ гэрийнхэндээ ярьж өгөх (Хүүрнэх) боломжийг аль болох олон болгож өгөх нь зүйтэй. “Өнөөдөр юу хийсэн тухайгаа 30 секундэд багтааж ярьцгаая” гэж хэлээд бүгд ээлжлэн ярьж болно. Ингэхэд хүүхэд сайн ярьж чадахгүй байвал, хэн нэг том хүн нь өгүүлбэр үлгэрлэн хэлж үзүүлээд дууриаж хэлж суртал нь давтана.

## Асуулт 20: Зурган харилцааны аргаар ажиллахад бүр ч хэлд орохгүй юм шиг санагдаад байна. Яагаад яриулахын оронд зурагт карт ашиглах ёстой юм бэ?

**Хариулт 20:** Зурагт карт нь тухайн нөхцөл байдал, хэлэх гэсэн санаагаа ойлгуулахын тулд ашигладаг хэрэглэгдэхүүн. Түүнчлэн хэлд орж амжаагүй хүүхэд өөрийнхөө хүссэн зүйл, сэтгэл санаагаа илэрхийлэхийн тулд нөгөө хүндээ өгч үзүүлэхэд ч хэрэглэнэ. Ямартай ч хэл яриаг орлуулах зорилгоор ашигладаг байна. Зураг ашигласан ч хэл ярианы хөгжилд огт саад болохгүй. Хамгийн чухал нь бусад хүнд өөрийн санаа бодлоо дамжуулах хүслийг нь дэмжих явдал юм. Зурагт карт зэрэг харааны тусламжтай дэмжлэгийн хэрэглэгдэхүүн ашиглахтай зэрэгцэн дуу авиа, үг хэллэг хэлүүлэх оролдлогыг (Дууриалгах) хийлгэнгээ хүүхэдтэйгээ харилцах нь чухал байдаг.



## Асуулт 21: Манай хүүхэд ярьдаг. Хүсч байгаагаа хэлж чадна. Тийм болохоор зурагт карт ашиглах шаардлагагүй биз дээ?

**Хариулт 21:** Нарийн төвөгтэй зүйл, анх удаа хийлгэх гэж байгаа зүйл дээр зөвөөр ойлгуулах болон санаа зовнилыг нь багасгах зорилгоор зурагт карт харуулангаа тайлбарлаж өгч болно. Гэхдээ хэтэрхий их ашиглах шаардлагагүй. Зөвхөн санаа өгөх нэмэлт мэдээлэл болгож ашигладаг. Чадах зүйлийг нь аль болох өөрөөр нь хийлгээрэй.

## Асуулт 22: Цэцэрлэг болон сургуульд аутизмгүй, жирийн хүүхдүүдтэй хамт сургавал илүү сайн нийгэмшиж, аутизм нь гайгүй болох болов уу?

**Хариулт 22:** Ижил буюу ойролцоо насны жирийн хүүхдүүдтэй харилцах, хамт суралцах орчин маш чухал байдаг. Энэ нь, харьцаж байгаа хүүхдээ ойлгож мэдрэх, үйлдлээ нөгөө хүүхдэдээ нийцүүлэх, олон хүүхэдтэй хамт байх чадварыг нь хөгжүүлдэг байна. Аль болох олон зүйл хийж туршлага нэмж л байвал найзтайгаа хамт байхын зугаатайг ойлгож, бусад хүүхэдтэй идэвхтэй харилцах, аливаа тоглоом, үйл ажиллагаанд хамтран оролцох хүсэл сонирхол нь улам нэмэгдэнэ. Эцсийн дүндээ нийгэмших байдал нь сайжирч, аутизмын нэг шинж болсон бусадтай тааруу харилцдаг байдлаа даван туулахад нь тустай юм. Тиймд хэл ярианы чадвар болон оюуны үйл ажиллагааны хөгжилд нь нийцүүлэн, өөрт нь хэцүү биш байдлаар бусадтай харилцах боломжийг бий болгож өгөх нь зүйтэй.



### **Асуулт 23: Өөрчлөлтөд маш дургүй. Аяг нь дагах уу яах вэ? Албаар өөрчлөх гэвэл сурч дасах болов уу?**

**Хариулт 23:** Төлөвлөсөн зүйл нь гэнэт өөрчлөгдөх, хийж хэвшсэн зүйлийнх нь дараалал алдагдах, тогтсон дүрмийг нь дагаагүй үед ихэд хямарч хүчтэй эсэргүүцэх байдал нь аутизмын гол шинж болдог. Эсэргүүцэж дургүйцлээ илэрхийлэх нь өөрт нь илүү амар санагддаг хүүхэд олон байдаг бөгөөд энэ нь тэдний хэт туйлширсан бодлоос шалтгаалах нь олонтаа. Хэр их эсэргүүцэхээс нь хамааран, аливаа өөрчлөлтөд бага багаар дасгах, эсвэл шинэ зүйлийг ойлгож хүлээж авах чадварыг нь хөгжүүлж өгөх хэрэгтэй болно. Тиймээс хүүхэдтэйгээ ярилцан, өчүүхэн жижиг өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч сурах дасгал хийлгээрэй. 9-10 насыг өнгөрөөд, төлөвлөсөн зүйл нь өөрчлөгдсөн ч ойлгож хүлээж авч сурсан аутизмтай хүүхдүүд олон байдаг.

### **Асуулт 24: Аутизмтай хүүхдэд ямар хоол хүнс тохиромжтой вэ? Найрлагад нь глютен, казеин ороогүй хоол хүнс өгөх ёстой юу?**

**Хариулт 24:** Аутизмын эмгэг шинжийг багасгаж, байдлыг нь сайжруулахад үр дүнтэй эм бэлдмэл, хоол тэжээлийн талаар судалж тогтоосон судалгаа шинжилгээний тайлан одоохондоо байхгүй. Жирийн хүүхэдтэй адилхан бие махбодын өсөлт болон эрүүл мэндэд нь тустай хоол хүнс өгөх нь чухал.

**Асуулт 25: Чихэрлэг зүйл, чипс, бургер, пицца, хийжүүлсэн ундаа, соус зэрэгт хэтэрхий дуртай. Иймэрхүү хүнс өсөлтөд нь хэр хортой вэ? Яаж болиулах вэ?**

**Хариулт 25:** Хортой хүнс гэх зүйл байхгүй. Харин хэт хэлбийсэн хооллолт нь шим тэжээлийн тэнцвэрийг алдагдуулж, эцсийн дүнд биед нь өөрчлөлт үзүүлэх тул өвчлөмтгий болгодог. “Хоёрхныг иднэ шүү”, “Нэг л халбага идээд боллоо”, “Ганцхан удаа шүү” гэх зэргээр идэж уух хэмжээг нь хүүхэдтэйгээ тохиролцон тогтоож өгөх байдлаар идүүлж сургах нь зохистой.



**Асуулт 26: Аутизмтай хүүхдэд өгч болохгүй эм байдаг уу? Нойрны эм, тайвшруулах эмийг удаан хэрэглэхэд гаж нөлөө байдаг уу?**

**Хариулт 26:** Аутизмтай хүүхдэд гэхээс илүүтэй тухайн хүүхдийн биеийн онцлог, бусад өвчин эмгэг зэргээс нь хамааран ийм төрлийн эм бэлдмэл өгөхийг хориглох тохиолдол байж болно. Эрүүл мэндтэй холбоотой асуудал тул эмчийн заавраар эм хэрэглэхийг зөвлөө.

## **Асуулт 27: Аутизмтай хүүхдэд мэдээгүйжүүлэлт хийж болох уу?**

**Хариулт 27:** Аутизмтай хүүхдэд гэхээс илүүтэй тухайн хүүхдийн биеийн онцлог, бусад өвчин эмгэг зэргээс нь хамааран мэдээ алдуулах эм өгөхийг хориглох тохиолдол байж болно. Эрүүл мэндтэй холбоотой асуудал тул эмчийн заавраар эм хэрэглэхийг зөвлөе.

## **Асуулт 28: Аутизмтай хүүхдэд уламжлалт эмчилгээ (Бариа засал, зүү төөнүүр зэрэг) үр дүн юу?**

**Хариулт 28:** Яг аутизмын эмгэг, түүнийг эмчилж засахад сайн нөлөөтэй гэсэн судалгааны үр дүн хараахан байхгүй. Гэхдээ сэтгэл санааг тайвшруулах, харилцааны чадавхийг дээшлүүлэх, анхаарал төвлөрөлтийг сайжруулах, үйлдлээ зохицуулах чадварыг нь дээшлүүлэх зэрэгт үр дүнтэй, сайн нөлөөтэй талаар тайланд дурьдагдсан нь бий. Тухайн хүүхдээсээ хамааран үр дүн, үр нөлөө нь харилцан адилгүй.



## **Асуулт 29: Яагаад өмд, хувцсаа тайлаад хаячихдаг юм бол? Ямар арга хэмжээ авах ёстой вэ?**

**Хариулт 29:** Бүх хүүхэд яг ижилхэн шалтгаанаар хувцсаа тайлаад байхгүй. Учир шалтгаан нь хүүхэд бүрт өөр. Тайлахын яг өмнөх урьтал нөхцөл (Үйл явдал, өдөөгч хүчин зүйл) нь янз бүр байдаг. Өмд, хувцсаа тайлчихдаг гэх мэт асуудалтай үйлдэлд дараах 4 шалтгаан байж болно.

1. Хүсч шаардах: Ямар нэг зүйл авахыг хүссэн бол тухайн зүйл, хийхийг хүссэнээ шаардаж буй байдал. Жишээ: “Чангаар орилж хашгирвал, ээж хүссэнийг минь өгдөг.”
2. Анхаарал татах: Хэн нэгний анхаарлыг татах гэсэн үйлдэл. Жишээ: “Хажууд ээжийг байхгүй байхад чангаар орилж хашгирвал, намайг аргадах гээд хүрээд ирдэг.”
3. Зугтах, зайлсхийх: Зугтах нь таагүй нөхцөл байдалтай учирвал, тэндээс зугтаж холдох гэсэн үйлдэл. Зайлсхийх нь таагүй нөхцөл байдалтай учрах гэж буйгаа урьдчилан мэдвэл, тэндээс зугтаж холдох гэсэн үйлдэл юм. Жишээ: “Чангаар орилж хашгирвал, ээж миний дургүй хоолыг өгөхөө болиод холдуулдаг.”
4. Мэдрэх: Мэдрэхүйгээр дамжуулан өөртөө нөлөөлөх гэсэн үйлдэл юм. Жишээлбэл, гараараа толгойгоо цохиж балбах үйлдэл бөгөөд толгойгоо балбах нь таатай мэдрэмж төрүүлдэг.

Юуны өмнө, хувцсаа тайлаад байдаг хүүхдийн тань үйлдэл дээрх 4 шалтгааны алинд нь хамаарч буй талаар эцэг эх, асран хамгаалагчид нь анзаарч бодох хэрэгтэй. Мөн, эцэг эх, асран хамгаалагч та бүхэн, хүүхэд тань хувцсаа тайлаад хаячихсаных нь дараа ямар арга хэмжээ авдаг вэ? Хүсч байгаа зүйл нь юу вэ гэдгийг мэдэж авсны үндсэн дээр хувцсаа тайлж хаяад байгаа тэр үйлдлийг нь орлуулах өөр ямар нэг үйлдлийг хүүхдээрээ хийлгэж болно.

## 2. СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АСРАН ХАМГААЛАГЧДЫН АСУУЛТ



## **Асуулт 1: Хүүхдээ ямар сургуульд оруулах ёстой вэ? Ердийн сургууль уу, тусгай сургууль уу? Гадаад улсад боловсрол эзэмшүүлэх нь илүү үр дүнтэй юм болов уу?**

**Хариулт 1:** Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ боловсрол олгох асуудалд өөрсдийн гэсэн үзэл бодлоор хандах нь зүйтэй. Аутизмтай байлаа ч хүүхэд бүхэн харилцан адилгүй тул тухайн хүүхдэд яг цав нийцсэн боловсролын орчин бүрдүүлнэ гэдэг боломжгүй. Ямар ч анги, сургууль сонгосон бай, давуу болон сул тал гарч ирнэ. Хүүхдийн тань хувьд сул тал их гэж та үзсэн бол тийм анги, сургуулийг сонгохгүй нь дээр байх. Сул тал гэдэг нь, тухайлбал хүүхэд тань харваас хэцүү байдалтай байдаг, тэнд байхаас маш ихээр дургүйцдэг бол өөрт нь тохирохгүй байж болно. Хүүхдийнхээ дуртайяа очихыг хүсэх тийм сургуулийг сонгох нь зүйтэй. Японд, тусгай хэрэгцээт боловсролын сургууль, ердийн сургуулийн алинд нь өгвөл илүү хөгждөг вэ гэсэн судалгааны талаар хэлэлцүүлэг ч өрнүүлж байсан бөгөөд зөвхөн хөгжлийн индексээр нь харвал хоорондоо бараг ялгаагүй байсан ба хүүхэд бүрийн онцлог болон тухайн орон нутгийн орчин нөхцөл зэргээс хамааран харилцан адилгүй байдаг гэжээ. Мөн, хүүхдээ юунд сургамаар байгаагаа эцэг эх, асран хамгаалагчид сайтар бодсоны үндсэн дээр суралцах сургуулийг нь сонгохыг зөвлөө.

## **Асуулт 2: Сэтгэл санаагаа зөв илэрхийлэхэд хэрхэн сургах вэ? Бусдын сэтгэл санааны байдлыг ойлгодог болгохын тулд яавал дээр вэ?**

**Хариулт 2:** Хөгжлийн бэрхшээл гэдэг утгаар аутизмын эмгэгийн гол онцлог шинж нь бусдын сэтгэл санааг ойлгохдоо муу хүүхэд олон байдаг явдал юм.


Мөн, өөрийн мэдэлгүй зөвхөн хүссэнээрээ үйлдэж илэрхийлэх гэх мэт онцлог шинж нь хүчтэй илэрдгийн улмаас өөрийнхөө сэтгэл санааг зөв зохистой илэрхийлж чадахгүй байх нь олонтаа. Өөрөөр хэлбэл, аутизмтай хүүхдийн хувьд энэ нь хамгийн муу чаддаг зүйл нь ч гэж болно. Өөрийнх нь болон бусдын сэтгэл санааны байдал хэмээх зүйл нь хэлбэр дүрсгүй, бас нүдэнд үл харагдах тул тэдэнд ойлгомжгүй, тодорхойгүй санагддаг байна.

Бусдын сэтгэл санааг ойлгож сургахын тулд, тухайн тохиолдол дахь сэтгэл санааны байдлыг үгэн хэлбэрт оруулан тодорхой болгож өгч болно. Жишээлбэл “Одоо ээжийнх нь сэтгэл санаа их сайхан байна”, “Тунгтай байна”, “Ууртай байна” гэх зэргээр хэлж ойлгуулах, эсвэл “Бэлэг аваад баяртай байгаа биз. Тийм бол “Баяртай байна” гээд хэл дээ” гэх зэргээр хүүхдээрээ хэлүүлнэ. Зөвхөн хэл яриагаар төдийгүй, сэтгэл санааны байдлыг заасан зурагт карт (Зураг тэмдэг, эможи зэрэг) харуулан зааж өгч болно. Ийм дасгалыг дахин давтан хийлгээд байвал аажимдаа сурдаг.

### Асуулт 3: Олон нийтийн газарт (Ресторан, кинотеатр, дэлгүүр) асуудалтай үйлдлүүд (Холбогдолгүй зүйл ярих, ганцаараа инээх, уурлаж хашгичих, хэт чанга ярих) гаргуулахгүй байхын тулд яах ёстой вэ?

**Хариулт 3:** Хүүхэд олон нийтийн газрын дэг журам, хориглох зүйлийг тодорхой хэмжээнд ойлгодог байх нь хамгийн чухал. Урьдчилан тайлбарлаад ч ойлгохгүй байвал, эхлээд дүрмийг дагах ёстой талаар хэлж өгнө. Мөн, хэл ярианы хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг загнаж зандрах, эсвэл хүчээр болиулбал харин хөөрхийлэлтэй. Олон нийтийн газарт дагуулж очихоос зайлсхийх биш, аажмаар дасган “Ингэж болохгүй”, эсвэл цагаа заагаад “6 цаг хүртэл тэвчих” гэж хэлэх зэргээр амархан, ойлгомжтой байдлаар зааварлан хэлж өгнө.

Нөгөө талаар, хүүхэд тань олон нийтийн газрын дэг журам, хориглох зүйлийн талаар ойлгосон ч, тэр газартаа очихоороо өөрөө ч мэдэлгүйгээр нөгөө үйлдлээ хийчихдэг тохиолдол цөөнгүй. Жишээ нь тухайн тохиолдолд нийцэхгүй үг, өгүүлбэрийг дахин давтан хэлээд байгаа тохиолдолд “Огт хамаагүй зүйл ярихаа болиорой” (Амаа таглаж харуулангаа) гэж анхааруулна. Мөн яагаад ч болихгүй байвал та өөрөө үлгэрлэн “Аяархан шивнэж яриарай” гэж хэлж өгнө. Гадагш гарахын өмнө “Хамаагүй гүйж харайгаад (Бусдад төвөгтэй санагдах) байж болохгүй. Үгэнд сайн орвол шагнана шүү”, “Ээж нь хоёрхон удаа хэлнэ. Гурав дахь удаагаа хэлүүлбэл, шууд гэртээ харина шүү” зэргээр хүүхэдтэйгээ урьдаар тохиролцож болно.



**Асуулт 4: Манай хүүхэд хэдэн сараас 1 жил орчмын хугацаанд ямар нэг зүйлийг хэт их сонирхон зөвхөн тэр тухайгаа ярьж бодох юм. Тэр нь амьдралд огт хэрэггүй зүйлүүд байдаг. Ийм туйлширмал сонирхлыг нь дэмжих үү, хориглох уу? Ингэж нэг зүйлд хэт донтож сонирхоод байгаа тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?**

**Хариулт 4:** Үүнд хүүхдийн туйлширмал хүсэл сонирхол, хэт явцуу байдал нөлөөлдөг. Бага насны хүүхдийн хувьд, тодорхой хэмжээнд аясыг нь дагуулах байдлаар сэтгэл санааг нь тайван байлгадаг. Харин арай том хүүхдэд, хүсэл сонирхол дээр нь хэт явцуу байдал нөлөөлдөг гэсэн үг биш. Эсрэгээрээ эргэн тойрныхоо хүмүүст сонсгох зорилгоор дахин давтаад байх тохиолдол элбэг. Тэрхүү хэт донтсон зүйлээ ярихгүй байлаа ч сэтгэл санаа нь хямрахгүй байж чадаж байвал, хамт байгаа хүмүүс нь аажмаар тоохгүй өнгөрүүлж байхыг зөвлөө. “Наадахаа өдөрт нэг л удаа хэлнэ шүү” гэж хүүхэдтэйгээ тохиролцох, эсвэл “Ээж нь наадахыг чинь сонсмооргүй байна” гэх зэргээр эрс няцаан хэлэх ч шаардлагатай болно. Ийм аргаар нөгөө хүн нь сонсох дургүй байгааг ойлгуулна. Жишээ нь, зарим аутизмтай хүүхдүүд “Чи яасан бүдүүн юм бэ?”, “Чиний толгой муу юу?” гэх мэт бүдүүлэг үгийг шуудхан хэлчихдэг.

Гэтэл энэ нь хүүхэд өөрөө заавал тэгж ярихыг хүсдэг буюу ярих дуртай сэдэв нь байдаг. Ийм үед хүүхэдтэй тохиролцох аргыг ашиглаж болно. Жишээлбэл “Чиний ярих гээд байгааг сонсохоос өмнө, эхлээд ээжийнхээ сонсохыг хүсч байгааг (Ангийнх нь хүүхдүүдийн тухай байж болно) яриарай. Хэрэв тэгвэл чиний яриаг ганц л удаа сонсоё” гэж болно. Эсвэл “5 минут хүлээж бай”, “Ээж нь завгүй байна. Үүнийг хийчихээд сонсоё” гэх зэргээр хэлж, хүлээж сурах дасгал хийлгэх нь зүйтэй. Бусадтай харилцах, нийгэмших чадварыг дээшлүүлэх сургалтад (Social Skill Training), хүүхдийг гэнэт яриад эхлэх биш, “Би ... тухай ярьж болох уу?” гэж асуусныхаа дараа ярьж эхлэх дасгал ажиллуулдаг. Ихэнх тохиолдолд тэр дороо болихгүй бөгөөд нөгөө хүнд чинь эвгүй, таагүй сэтгэгдэл төрдөг юм шүү гэдгийг дахин давтан хэлж өгч байхыг зөвлөө. Мөн ярихыг үнэхээр их хүссэн үедээ яах ёстой, хэрхэн тэвчээртэй хандах талаар зааж өгөх нь зүйтэй.



**Асуулт 5: Манай хүүхэд шилжилтийн насандаа орчихсон. Биед нь гарч буй өөрчлөлтийг гайхаж хүлээж аваад байх шиг байна. Бэлгийн бойжилт, хөгжлийн талаар хэрхэн яаж тайлбарлаж өгөх вэ? Хэдэн настай үед нь хэлж өгвөл хамгийн тохиромжтой вэ?**

**Хариулт 5:** Хэвийн хөгжилтэй хүүхэд ч шилжилтийн насны бие махбод болон сэтгэл санааны өөрчлөлт хувиралтад тулгамдаж сандрах нь хэвийн үзэгдэл юм. Өөрчлөлтийг биеэрээ үзэж байж, тэрхүү өөрчлөлтийг таньж ойлгодог. Ер нь, тайлбарлахад шууд ойлгодог хүүхэд тийм ч олон биш. Аутизмтай хүүхэд ч ялгаагүй. Тиймд, тохиолдож буй өөрчлөлтийг хэрхэн хүлээж авах, ямар арга хэмжээ авах тухай тодорхой зааж өгөх хэрэгтэй. Танин мэдэх чадвар, хэл яриа ойлгох чадварт нь тохируулан ойлгоход хялбар зураг, авах арга хэмжээний дараалал зэргийг харуулсан үзүүлэн ашиглан зааж болно. Гол нь хүүхдэдээ айдас зовнил төрүүлэхгүй, тайван хүлээж авах байдлаар ажиллах нь зүйтэй.

**Асуулт 6: Шилжилтийн насанд ороход аутизмтай хүүхдийн зан төлөв хэрхэн өөрчлөгдөх вэ? Зан ааш, мэдрэхүй, оюун ухаанд нь эерэг болон сөрөг ямар өөрчлөлтүүд ажиглагдах вэ?**

**Хариулт 6:** Аутизмтай хүүхдийн шилжилтийн насан дахь зан төлвийн өөрчлөлтийн талаар тусгайлсан ойлголт байдаггүй. Бие махбодод өөрчлөлт гарахын зэрэгцээ орчин тойронтойгоо холбоотойгоор сэтгэл санааны хувьд тайван бус болох нь бий. Мөн, зарим хүүхдэд уналт таталт илрэх тохиолдол ч цөөнгүй. Энэ мэт сэтгэл санааны тайван бус байдал, уналт таталт илэрч буй тохиолдолд зөвхөн бие махбодод нөлөөлөөд зогсохгүй, мэдрэхүй болон оюуны үйл ажиллагаанд нь ч янз бүрийн өөрчлөлт гардаг байна. Тиймээс юуны өмнө сэтгэл санааны тайван байдлыг хадгалахад анхааран, эрүүл байх нөхцлийг нь бүрдүүлж өгөхийг зөвлөө.

**Асуулт 7: Манай хүүхэд ялагдах тун дургүй. Ялангуяа хожиг чадахаар байсан тоглоомонд хожигдвол маш их уурладаг, эсвэл уйлчихдаг. Хожигдох үе байдаг гэдгийг яаж ойлгуулах вэ? Санаснаар нь болохгүй тохиолдол гардгийг хэрхэн ойлгуулж хүлээн зөвшөөрүүлэх вэ?**

**Хариулт 7:** Түрүүлэх ёстой, би л нэгдүгээрт байх ёстой гэсэн явцуу бодолтой, эсрэгээрээ хожигдох дургүй, нэгдүгээрт орж чадаагүй бол ихэд гутран, сэтгэл санаа нь хямарч тогтворгүй болдог хэвшмэл бодолтой аутизмтай хүүхэд элбэг тохиолдоно. Аливаа зүйлд өөрийгөө тэргүүнд тавьдаг, санаснаар нь болоогүй тохиолдолд ихэд эсэргүүцэн тухайн нөхцөл байдалд хэт хүчтэй хариу үйлдэл үзүүлэх нь аутизмын шинж тэмдгээс шалтгаалсан үйлдэл юм. Уг нь ялж ялагддаг, хожигддог үе байдаг гэдгийг сайтар мэддэг боловч тухайн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй, таалагдахгүй байна гэсэн сэтгэл санааны байдлаа огт тэвчиж чадахгүй байх тохиолдол цөөнгүй. “Хожигдсон ч уйлахгүй, уурлахгүй”, “Уурладаггүй хүн хамгийн мундаг нь” гэх зэргээр урьдчилан хэлж ойлгуулах, эсвэл олон давтагдах явцад уйлахгүй байх, эсвэл уурлаж хямарсан ч хэвийн байдалдаа хурдан буцаж орж байвал магтаж урамшуулах замаар аажим аажмаар ойлгож хүлээн зөвшөөрөхөд сургадаг.

**Асуулт 8: “Ингэвэл яах вэ, тэгвэл яах вэ” гээд байнга санаа нь зовж түгшдэг. Хажуу хавирганыхаа бусад хүмүүст ч төвөгтэй. Бас бүгдийг урьдчилж мэдэх гээд зүтгэчихнэ. Ямар нэг тодорхой зүйл олж мэдэхгүй бол санаа нь зовоод салахгүй. Түгшүүртэй байдлыг нь яаж бууруулах вэ?**

**Хариулт 8:** Хэт хүчтэй мэдрэхүй, туйлширмал байдлаас нь улбаатай. Бусдын хэлснийг сонсох төдийхөнд санаа нь амардаггүй тул дахин дахин асууж шалгаах, эсвэл санаа зовж буй байдлаа байхгүй болгохын тулд ингэдэг байх. Зөвхөн тайлбарлаж хэлээд орхилгүй, бичиг тэмдэглэл, фото болон зурмал зургаар харуулж ойлгуулах замаар сэтгэл санааны тайван бус байдлыг нь багасгаж өгөх нь зүйтэй.

## **Асуулт 9: Манай хүүхэд баяр хөөр, уур бухимдал, уйтгар гунигаа олны дунд байсан ч хэт хүчтэй илэрхийлдэг. Өндөр чадварын аутизмтай хүүхдийг (Том) сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадварт хэрхэн сургах вэ?**

**Хариулт 9:** Хэт их сэтгэлийн хөдөлгөөнтэй, сэтгэл хөдлөлийн байдал нь огцом өөрчлөгддөг аутизмтай хүүхэд цөөнгүй байдаг. Хэт сэтгэл хөдлөлд автуулахгүйн тулд өдөр тутамд аль болох хүчтэй өдөөхгүй байх нь чухал. Өөрөөр хэлбэл, онцын шаардлагагүй бол хөөргөж онгиороох, дэргэд нь чанга дуугаар уурлаж хашгичих зэргээс зайлсхийх хэрэгтэй. Уурлаж бухимдахаас эхлээд тайван бус байх, гуниглах гэх мэт сэтгэл хөдлөлийн түвшингээ хараад ойлгохуйцаар зураг, картын хэлбэрт оруулан тоогоор илэрхийлж үзүүлэх, эсвэл энгийн янз бүрийн тохиолдол, нөхцөл байдал дунд сэтгэл хөдлөлийн олон төрөл, их багын талаар (“Яг одоо би жаахан гунигтай/ууртай байна. Түвшин нь 2” гэх мэтчилэн) ярьж өгөөрэй. Тэгээд сэтгэл хөдлөлийн түвшиндээ тааруулан ямар үйлдэл хийх ёстойг нь ярилцаж болно. Тухайлбал “Түвшин 4 болчихвол, ганцаараа өөр өрөөнд орж болно”, “Түвшин 5 болчихлоо гэж бодож байвал хажуудаа байгаа хэн нэгнээс, миний сэтгэлийн түвшин 5 болчихлоо, надад туслаач” гэж хэлж сургаарай.

## **Асуулт 10: Бусад хүүхэдтэй харьцуулан, ямар нэг сул талаа олоод мэдчихвэл (Жишээ нь, өөрийгөө бусдаас намхан нуруутай гэх), би яавал өөр болох юм бэ гэж их шалгаадаг. Хүн бүр харилцан адилгүй гэдгийг яаж тайлбарлавал зүгээр вэ?**

**Хариулт 10:** Хүмүүсийн бие физиологийн онцлог, зан ааш олон янз байдгийг ухаарч мэдэх нь аутизмтай хүүхдийн хувьд, маш тодорхойгүй зүйлийг ойлгож хүлээн авах асуудал болохын сацуу өргөн хүрээний мэдлэг олж авах үйл явц ч гэж болно.

Хүн ба үйл явдалтай учрах тохиолдлууд болон үзэж сонсох зүйлийг нь аль болох олон байлгаж туршлагажуулах хэрэгтэй. Аутизмтай хүүхэд хэт хэлбийсэн сонирхлоосоо үүдэлтэйгээр, жишээ нь нуруугаар намхан, хэт тарган хүнийг нүд салгалгүй сониучирхаж харах зэргээр бусдын зарим сул тал болон нүдэнд харагдах онцлог шинжийг учир зүтгүй сонирхдог. Улмаар хэт туйлширдаг зангаасаа болоод “Чи яасан намхан юм бэ?”, “Гэдэс чинь яагаад ийм том юм бэ?” гэх мэтчилэн олон дахин нуршиж асуух, анхааруулж хэлсэн ч зогсохгүй шалгаах зэрэг байдал гаргадаг. Бусад хүний сул тал, бусдаас өөр байдал зэрэг барагтай бол өөрчлөх аргагүй зүйлийг, цаад хүнийнхээ сэтгэл санааг бодолгүйгээр хэлчихдэг. Бусад хүний сэтгэл санаа, хэлэх гэсэн зүйлийг ойлгох тал дээр хүндрэл үүсдэг байна. Ойлгох гэдэг нь хэлж ярих, асуухаас огт өөр асуудал юм. Гэтэл таагүй үг сонссон нөгөө хүнд нь онцгүй санагдана гэдгийг (Гомдож дургүйцэх) бага багаар ойлгуулах шаардлагатай болно. Харин аутизмтай хүүхдийн хувьд иймэрхүү зүйлийг ойлгох нас нь бусад хэвийн хүүхэдтэй харьцуулахад нилээд хожуу гэгддэг (Уйгагүй зааж сургавал 10 хэдэн наснаас 20 гаруй насандаа ойлгодог). Бусад хүн дургүйцэхээр үг хэлж, эсвэл асууж буй байдал болон “Тарган хүн юм идэхгүй нь дээр”, “Навтгар болохоор өрөвдөлтэй харагдаж байна” гэх мэт таагүй үгс хэлж буй бодит тохиолдлуудыг зурагт ном, кино зэргээс үзүүлж харуулах, эсвэл өдөр тутамд тиймэрхүү үг сонссон хүнд ямар гомдмоор санагддаг талаар хэлж тайлбарлаж өгөх нь зүйтэй. Жишээ нь “Чамд намхан/бүдүүн гэж хэлүүлсэн хүн чинь уйлаад/уурлаад байгаа биз” гэж хэлж өгнө (Янз бүрийн нүүрний хувирал, сэтгэл санааны байдлыг харуулсан зурагтай карт ашиглаж ч болно). Олонтаа давтан тайлбарлаж хэлж өгөөд байвал ойлгодог болно.

## Асуулт 11: Хүнд хэлбэрийн сонгодог аутизмтай залуу стресстэй, ууртай байгаа үед нь хэрхэн тайвшруулах вэ? Эмийн эмчилгээ зайлшгүй шаардлагатай юу?

**Хариулт 11:** Стрессийг арилгах, тайлах арга хүн бүрт харилцан адилгүй. “Аутизмтай хүнийг ингэж тайвшруулна” гэсэн тогтсон арга гэж байхгүй. Дасгал хөдөлгөөн хийлгэх, телевизор, дүрс бичлэг харуулах, автомашин, үлэг гүрвэлийн зурагтай ном үзүүлэх, шүршүүрт оруулах зэргээр тухайн хүнд тохирсон тайвшруулах аргыг өдөр тутмын амьдралын явцад олж илрүүлэх нь зүйтэй. Тайвшруулахын тулд, чадвал зөвхөн ганц биш хэд хэдэн эд зүйл болон үйлдлийг бэлтгэвэл зүгээр.



## **Асуулт 12: Аутизмтай хүүхэдтэй хамт өсч байгаа ах эгч, дүүгийнх нь хувьд ирээдүйд ямар асуудал, дарамт учрах эрсдэлтэй вэ?**

**Хариулт 12:** Гэр бүлд нь зөвхөн аутизм ч гэлтгүй, ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бол сэтгэл зүйн болон эдийн засгийн хувьд, түүнчлэн шууд болон дам утгаар гэр бүл, ах дүүд нь ирэх ачаалал ихэснэ. Тодорхойлбол асаргаа, түүнтэй уялдан үүсэх цаг хугацаа, мөнгө санхүүгийн дарамт юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх нийгмийн болон эргэн тойрных нь ойлголт, хандлага хэр байгаагаас хамаарч сэтгэл зүйн дарамт ч нэмэгдэнэ. Мэдээж, ийм ачаалал дарамт нь стресс болж удаан хугацааны туршид хуримтлагдвал, гэр бүлийнхний хооронд болон бусадтай харилцах харилцаа, аливааг ойлгож хүлээн авах байдал, танин мэдэх үйл явцад нь туйлширсан байдлыг үүсгэх магадлалтай. Аль болох эрүүл сэтгэл зүйн орчин, эрүүл ахуйг бий болгож өгөх нь туйлын чухал. Гэвч зөвхөн ах дүүг нь амар байлгаж байгаа нь энэ гээд аутизмтай хүүхдийг гэрийнхэнтэй нь харьцуулахгүй, холдуулж хэрхэвч болохгүй. Ах дүү нар нь ч, нэг гэрийнх гэдэг утгаараа аутизмтай хүүхэдтэй сурмаг харилцах аргад суралцаж, чадвар боломжоо хэтрүүлэхгүй байдлаар өөрийнхөөрөө байх нь зүйтэй болов уу.

## **Асуулт 13: Манай хүүхэд ном унших дургүй. Номонд дуртай болгохын тулд хичээж ажиллах хэрэгтэй юу?**

**Хариулт 13:** Хэл ярианы чадвар болон үгийн баялгийг нь нэмэгдүүлэхээс гадна ном уншуулах нь маш чухал байдаг. Гэхдээ дургүй зүйлийг нь хүчээр хийлгэхийн оронд сайн талыг нь илүү хөгжүүлж өгөх нь бас чухал юм. Эх хэлийг нь сайн сургахын тулд тогтсон зүйл, үйл ажиллагаан дээрээ сайтар хичээлгэж ажиллахыг зөвлөө. Илүү их зүйлийг сургах гэж буй бол, хүүхэдтэйгээ өөртэй нь сайн ярилцангаа санал болгож болно.





### **Асуулт 14: Шилжилтийн насанд нь юуг илүү анхаарах вэ? Би яаж найз охинтой болох вэ гэж их асуудаг. Юу гэж хариулсан нь дээр вэ?**

**Хариулт 14:** Зохистой түвшинд эсрэг хүйсийнхээ хүнтэй, мөн бусад хүнтэй харилцах харилцааг бий болгох нь чухал. Тиймээс бусадтай найзлаж нөхөрлөх, харилцах соёлыг сайтар зааж сургах хэрэгтэй. Зөвхөн өөрийгөө чухалчлах болон бусдад төвөг учруулахуйц үйлдэл гаргаж болохгүй гэдгийг ойлгуулахаас эхлэх ёстой. Хэн нэгэнд дурлаж, хайрлах нь мэдээж сайн сайхан зүйл. Гэвч эсрэгээрээ, өөрийгөө хайрлуулахын тулд хичээж зүтгэх шаардлагатай болно гэсэн үг. Мөн ямар эрэгтэй, эсвэл эмэгтэй хүнд татагддаг талаар нь хамт суугаад ярилцаж үзэж болно гэж хэлээд үзээрэй.

### **Асуулт 15: Аспергерийн хам шинжтэй гэж оношлогдсон хүний хүүхэд нь бас аспергертэй төрөх үү? (Удамшдаг уу)**

**Хариулт 15:** Аутизмын хүрээний бэрхшээлтэй холбоотой удамзүйн тухай тов тодорхой тайлбар байдаггүй. Тиймээс ямар хувь хэмжээгээр удамшдаг нь хараахан тодорхойгүй байсаар. Эцэг эхийнх нь аль нэг нь үү, эсвэл хоёулаа юу гэдгээс нь хамаарч өөр байна. Эцэг эхийнх нь онцлог хүүхдэд нь удамших гэдэг тодорхой хэмжээнд л байж болох магадлалтай тул аутизмын хүрээний бэрхшээлтэй эцэг эхийн тэрхүү онцлог их үү, бага уу гэдгээс үл хамаараад хүүхдэд нь удамших магадлалтай гэж үздэг.



**Асуулт 16: Манай хүүхэд гудамжинд зарим хүмүүсийг харвал “Миний дургүй царай”, “Аймаар царайтай хүн” гэх мэтээр эмзэг хүлээж авдаг. Ийм үед, сэтгэл хөдлөл болон үйлдэл мэдрэмжээ зөв хянаж, удирдаж сургахын тулд юу ойлгуулах ёстой вэ?**

**Хариулт 16:** Аутизмтай хүн өнгөрсөн таагүй дурсамж, айдастай үйл явдлыг маш тод санадаг ба сэтгэлд нь стресс болж үлддэг. Тэрхүү дурсамж нь ямар нэг хүнд, эсвэл нүүр царайнд хандах хандлагаар нь илрэх тохиолдол цөөнгүй. Тийм хүнтэй уулзвал, сэтгэл санаа нь хүчтэй хямардаг байна. Ийм тохиолдолд, хэт мэдрэмтгий байдлыг нь хүчтэй илтгэдэг өдөөгч хүчин зүйл болон үйл явдал тохиолдсон үед тэдгээрт авах арга хэмжээ нь ижилхэн байна.

**Асуулт 17: Манай хүүхэд хэлснийг дорхноо мартдаг. Хэлснийг хийж байхдаа, эсвэл хийж эхлэхээсээ өмнө мартчихдаг. Зааж өгснөө давтуулахад, өдөр болгон хийдэг зүйлээ ч хүртэл мартчихна. Тогтоох чадварыг нь яаж сайжруулах вэ?**

**Хариулт 17:** Тогтоох чадвар сул байхыг аутизмаас болсон гэх аргагүй. Оюуны бэрхшээлтэй, эсвэл оюуны хөгжил удаантай тохиолдолд, танин мэдэх чадвартай адилаар ой тогтоолт сул байх нь цөөнгүй байдаг. Ямар нэг зүйлийг мартахагүй сануулж байхын тулд, тогтоолгох гэж байгаа тухайн зүйлдээ анхаарлыг нь төвлөрүүлэх нь чухал юм. Мөн өөрт нь “Би мартахагүй санаж байх ёстой”, “Алдаа гаргахгүйн тулд анхаарах хэрэгтэй” гэсэн бодол бий болсон байх шаардлагатай. Аутизмтай хүмүүсийн ой тогтоолт нь хэл яриагаар өгсөн мэдээллийг сонсож тогтоохдоо сайн, эсвэл зураг, бичвэр зэргийг хараад цээжилж тогтоохдоо сайн гэсэн хоёр янз байдаг. Танай хүүхэд энэ хоёрын алинд нь илүү сайн бэ гэдгийг мэдэж авсны үндсэн дээр түүнд нь тохирсон цээжлэх, тогтоох аргыг ашиглаж, санаа хэлж өгч байхыг зөвлөө.

**Асуулт 18: Бусдын дэргэд биеэ зөв авч явахыг олон удаа сануулах боловч мартчих юм. Жишээ нь, гэрт зочинтой байхад өмнүүр нь дотуур өмдтэйгээ яваад байж болохгүй гэж зөндөө хэлсэн ч дорхноо мартчихдаг. Дадал хэвшил болговол зохих ийм зүйлийг хэрхэн ойлгуулж, сургах вэ?**

**Хариулт 18:** Олон дахин зааж өгч байж л амьдралын дадал хэвшил болон олон нийтийн дунд бие авч явах соёл, дэг журмыг ойлгуулна. Хамгийн гол нь хүүхдийнхээ танин мэдэх болон хэл яриаг ойлгох чадварт тохирсон байдлаар зааж (Хэлж ярих, тайлбарлах, тодорхой үйлдэл хийх зэрэг) чадаж буй эсэх. Түүнчлэн “Ичмээр юм”, “Гоё байна” гэж хэр олон удаа хүүхэддээ хэлж өгч байгаа нь чухал юм. Аль болох олон удаа хэлж, уйгагүй зааж өгөөрэй.

**Асуулт 19: Өөрийгөө тайтгаруулахын тулд, ямар ч утга учиргүй зүйлийг дахин давтан яриад байдаг. Жишээлбэл “Дүү архи уудаг” гэх зэргээр хэлдэг. Үүнийг яаж болиулах вэ?**

**Хариулт 19:** Ганцаараа ярьдаг байдал болон зан үйлийн шинжтэй үйлдэл нь бүгд муу гэсэн үг огт биш юм. Хэлж ярьж, үйлдэл хийж буй цаг үе, нөхцөл байдал нь хэрэв тохиромжгүй санагдвал анхааруулаад, эргэн тойрныхоо хүмүүст саад төвөг учруулахааргүй өөр өрөө, өөр газарт очиж хийгээрэй гэж хэлэх нь зүйтэй.

**Асуулт 20: Манай хүүхэд сэтгэл нь хөдөлбөл хачин үйлдэл гаргадаг. Жишээлбэл, гэнэт бүжиглэж, чангаар инээж, утга учиргүй юм ярьдаг. Ийм үед сэтгэлийн хөдөлгөөнөө хянаж сургахын тулд яах ёстой вэ?**

**Хариулт 20:** Этгээд үйлдэл гэж та бодож байгаа ч тэр нь эргэн тойрондоо төвөг учруулахаар биш бол албадаж болиулах нь арай хатуудах байх. Асуулт 16-д дурьдсантай төстэй арга хэмжээ авч болно.

**Асуулт 21: Манай хүүхэд сурах дургүй. Сургууль, багш, хичээлд ямар ч сонирхолгүй. Ийм тохиолдолд ямар аргаар заавал зүгээр вэ? Яаж хичээллүүлж болох вэ?**

**Хариулт 21:** Зөвхөн аутизмтай хүүхэд л ийм байдаг гэсэн үг биш болов уу. Оюуны хөгжил бага зэрэг хоцрогдолтой, эсвэл суралцахуйн бэрхшээлтэй (Уншиж бичих, тоо бодох зэрэг суралцах тал дээр нэлээд хүндрэлтэй) байж болох юм. Хэрэв тийм бол цаг гарган удаан нягт нямбай заах, ойлгоход амархнаар санаа хэлж өгөх, хүүхдийнхээ анхаарлаа төвлөрүүлж чадах хугацаанд нь тааруулан цагаа өөрчилж болно. Мөн, хэт нэг тийш хандсан сонирхолтой учраас хичээлдээ тогтож сууж чадахгүй байвал, сонирхлыг нь татахуйц сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах, тоглох цаг гаргах зохицуулалт хийх зэргээр хичээж чармайх боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй.

## **Асуулт 22: Аутизмтай гэдгийг нь өөрт нь хэзээ хэлж өгвөл дээр вэ? Хэлэхдээ хэрхэн тайлбарлаж ойлгуулбал, хүүхэд маань зөвөөр хүлээж авах бол?**

**Хариулт 22:** Хүүхэд тань өөрөө сонирхож асуугаад байвал “Аутизм гэдэг онош гэсэн шүү” гэж хэлж өгч болно. Харин хүүхэд тань өөрөө асуугаагүй байхад нь хэлэх гэсний хэрэггүй. Гэхдээ, хүүхдэд бэрхшээлийнх нь талаар хэлж өгөх тухай олон янзын үзэл бодол байдаг. Тиймд хүүхдийг тань сайн мэдэх багш зэрэг хүмүүстэй сайтар ярилцан зөвлөж байж хэлэх нь зүйтэй. Япон, АНУ зэрэг улсад 9-10 наснаас нь хойш хүүхдэд зориулсан аутизмыг тухай тайлбарласан зурагтай ном (Ухуулан таниулах материал) ашиглан тайлбарлах туршлагууд ч байдаг.

## **Асуулт 23: Охин хүүхдэд анхны сарын тэмдэг ирэхээс өмнө ямар бэлтгэл хийх вэ? Шинэ зүйлийг хүлээж авахад хугацаа их шаарддаг. Тийм болохоор цус харах, эсвэл ариун цэврийн хэрэглэл хэрэглэхээс цааргалж эсэргүүцдэг болов уу?**

**Хариулт 23:** Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хувьд үүнийг ойлгох тал дээр маш хэцүү байдаг учир, сарын тэмдэг ирэх үед зарим нь өөрийгөө арчилж чаддаггүй. Нөгөөтэйгүүр, аутизмтай учраас өөрөө хийхээс цааргалдаг, эсвэл чаддаггүй гэдэг жишээ бараг байхгүй.

## **Асуулт 24: Эсрэг хүйсийнхээ хүнд татагдах, бэлгийн сонирхол бий болсон тохиолдолд яах ёстой вэ?**

**Хариулт 24:** Жирийн хүүхэдтэй яг ижилхэн. Ялангуяа, аутизмтай учраас тусгайлан заах ёстой арга гэж байхгүй. Бэлгийн сонирхлын тухайд гэвэл, насанд хүрэх гэж буй нэг алхам гэж ойлгоно. Хэт их, хэт бага биш байдлаар хүүхдэд тохирсон зөв мэдээллийг өгөх нь зүйтэй.

## **Асуулт 25: Юунд дуртайгаа өөрөө ч сайн мэдэхгүй байх шиг. Дуртай зүйлтэй болчихвол, хий дэмий эргэлдээд байдаг нь цөөрөх байх гэж бодох юм. Яаж дуртай зүйлийг нь олох вэ?**

**Хариулт 25:** Ижил насны хүүхдүүдийн шохоорхдог зүйл, насаар арай бага хүүхдүүдийн сонирхдог зүйлийг санал болгоод, ямар хариу үйлдэл үзүүлэхийг нь анзаараарай. Ганц хоёрхон удаад сонирхолтой санагдах үгүйгээ хүүхэд өөрөө сайн ойлгохгүй байж магадгүй тул арай олон удаа оролдуулж үзэх нь чухал юм. Мөн гэр бүлээрээ хамтдаа хийн зугаатай, сонирхолтой байгаа мэт царай, янз байдал гаргаж үзүүлэх нь ч чухал байдаг бөгөөд тэр байдлыг тань хараад дуртай болох тохиолдол ч цөөнгүй.

## **Асуулт 26: Өөрийн мэдэлгүй, эсвэл бэлэг эрхтнээ зориуд үрж, өдөр бүр дур тавиад байгаа бололтой. Энэ зүгээр үү? Багасгах шаардлагатай юу? Ийм тохиолдолд яах ёстой вэ?**

**Хариулт 26:** Өөрийн мэдэлгүй дур тавиад байгаа бол яах ч аргагүй. Бие махбод, эрүүл мэндэд нь онцын муу нөлөөгүй. Бэлэг эрхтнийг нь шүргэж үрээд байхааргүй өмд хувцас өмсүүлэх, тийм боломж гарахааргүй орчинд байлгах зэрэг арга бодож олох хэрэгтэй.

## **Асуулт 27: Бохир, цэвэр зэрэг ойлголтыг хэрхэн заах вэ? Жишээлбэл, нийтийн бие засах газарт суултуурыг нь муухай гэж бодохгүй суух, эсвэл элдэв бохир хог барьж аваад хогийн саванд хийчихдэг. Заваан, хүрч болохгүй, нян үрждэг гэх мэтийг хэрхэн ойлгуулах вэ?**

**Хариулт 27:** Том жижиг, урт богино, цэвэр бохир, олон цөөн гэсэн тодорхойгүй ухагдахууныг ойлгох нь аутизмтай хүүхдийн хувьд маш төвөгтэй зүйл гэж болно. Гэтэл ямар байвал цэвэрхэн, ямар байвал бохир юм бэ гэдгийг зааглаж ялгах боломжгүй. Иймэрхүү тодорхой бус, нүдэнд харагдахгүй зүйлийг ойлгох нь хүүхдээс оюуны болон танин мэдэхүйн өндөр чадварыг шаардана. Суултуурт гар хүрэхээс нь өмнө, эсвэл суухаас нь өмнө “Бохир байна, болохгүй”, “Цэвэрхэн байна, болно” гэх зэргээр хэлж зааварлах байдлаар сургаж хэвшүүлэхээс өөр аргагүй. Үүнийг багаас нь уйгагүй зааж сургах шаардлагатай бөгөөд үргэлж очдог газар нь байвал хүүхэд сурч тогтоох боломжтой.

## **Асуулт 28: Олон нийтийн газарт явж байгаад төөрчихвөл хаана, ямар цэгт очих ёстойг нь хэрхэн ойлгуулах вэ? Японд үүнийг яаж ойлгуулдаг вэ?**

**Хариулт 28:** Тухайн барилга байгууламжаас хамааран өөр байдаг. Уулзах ёстой цэгээ заах бус, хэрэв төөрчихвөл ойр хавьдаа байгаа дэлгүүр, үйлчилгээний газрын хүн, эсвэл хамгаалалтын ажилтан зэрэг хүмүүст биедээ байнга авч явдаг “Төөрсөн хүүхдийн карт”-аа (Овог нэр, гэрийн хаяг, холбо барих утсыг нь тэмдэглэсэн) үзүүлэх, эсвэл “Би төөрчихлөө. Надад туслаач” гэж хэлж сурах дадлага хийлгэх нь зүйтэй. Хэрэв дундаас дээш ангийн хүүхэд бол гар утас ашиглуулах, утсаар өөрөө холбоо барьж сургавал зүгээр.

## **Асуулт 29: Аутизмтай хүүхэд булчингийн сулралтай, тэнцвэрийн мэдрэхүй тааруу байдаг. Ямар дасгал хөдөлгөөн, сургалтаар сайжруулах боломжтой вэ?**

**Хариулт 29:** Аутизмын эмгэг бэрхшээлийн онцлогийн тухайд, булчингийн сулралтай болон тэнцвэрийн мэдрэхүй тааруу гэсэн судалгаа, дүгнэлт бараг байхгүй. Ийм тал анзаарагдаж байгаа нь хөгжлийн хэт хоцрогдлыг (Ялангуяа хөдөлгөөний үйл ажиллагааны хоцрогдол) дагуулдаг оюуны хөгжлийн бэрхшээлд илэрдэг шинж тэмдэг юм. Зөв хооллон бие махбодыг нь эрүүл чийрэг байлгаж, тоглоомын явцад болон өдөр тутмын амьдрал дунд булчинг нь хөдөлгөж чангалах зэрэг тэнцвэрийн мэдрэхүйг нь хөгжүүлэх дасгал хөдөлгөөн хийлгэж болно. Ялангуяа гадаа тоглуулах, тоглоомоор тоглуулах зэрэг нь үр дүнтэй байдаг.



**Асуулт 30: Хэл яриа бэрхшээлтэй (Ярьдаггүй) аутизмтай хүүхдэд, биеийнхээ байдлыг хэлж чаддаг болгохын тулд эхлээд юу ойлгуулж, хэрхэн илэрхийлдэг болгох вэ? Жишээлбэл, гэдэс өвдөж байна, хоолой өвдчихлөө гэх мэт.**

**Хариулт 30:** Гэр бүл, эргэн тойрны хүмүүс нь өдөр тутамд “... өвдөж байна”, “Дотор муухай оргиж байна”, “Халуурч байна” гэх мэт биеийнхээ таагүй байдлыг зөвхөн үгээр хэлэх төдийгүй, ойлгомжтой зураг, карт зэргийг ашиглах ба үүнийгээ хүүхэддээ ч харуулна. Хэрэв хүүхэд тань бие нь таагүй байгаа янз байдал гаргаж байвал “Гэдэс чинь өвдөөд байгаа юм уу”, “Халуунтай байна шүү дээ” гэх мэтчилэн үгээр хэлж асуухын зэрэгцээ зураг, карт зэргийг харуулан зааж өгөх нь зүйтэй. Үнэхээр бие нь таагүй байгаа эсэхийг асуухдаа, жишээлбэл толгой нь өвдсөн хүний зураг бүхий картыг болон сэргэлэн цовоо байгаа хүний зурагтай карттай зэрэг харуулаад, аль нэгийг нь сонгуулах маягаар дасгал сургууль хийж болно.



“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай  
хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн  
хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

2018 оны 9 дүгээр сар  
Улаанбаатар хот